



Удирдах зөвлөлийн хуралдааны 2021 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 08 дугаартай тогтоолдоор батлав

ТӨВЛӨРСӨН ХУРИМТЛАЛААС ГИШҮҮДЭД ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЭХ, САЛБАР ЗӨВЛӨЛД УРАМШИЛ ОЛГОХ ГИШҮҮДИЙГ
ХУРИМТЛАЛ ТӨВЛӨРҮҮЛЭХЭЭС ЧӨЛӨӨЛӨХ, ХӨНГӨЛ
ҮЗҮҮЛЭХ АХМАДЫН САНГААС ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ.

Нэг. Зорилго.

Журмын зорилго нь гишүүдэд үзүүлэх мөнгөн дэмжлэгийг шуурхай зохион байгуулах, Ахмадын зөвлөлд урамшил олгох, гишүүнийг татвар, хуримтлал /цаашид хуримтлал гэх/ нэгтгэн төвлөрүүлэхээс чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, "Ахмадын сан"-гаас тусlamж үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Мөнгөн дэмжлэг үзүүлэх үндэслэл, түүний хэмжээ.

2. Доорхи тохиолдолд журамд заасан хэмжээгээр гишүүдэд мөнгөн дэмжлэг үзүүлж болно.

2.1. Гишүүн түүний эхнэр, нөхөр нас нөгчихөд 60 000 -100 000 төгрөг,

2.2. Гишүүн хүндээр өвчлөх /мэс засалд орох болон удаан хугацаагаар эмчлэгдэх/-д 50 000-80 000 төгрөг,

2.3. Нийслэл, түүний ойролцоо эмнэлэгт хэвтэх, амралт сувилалд нэгдсэн журмаар үйлчлүүлэхэд 30 000- 70 000 төгрөг,

2.4. Бусдын арамжид байгаа ахмадыг эргэх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэхэд 30 000 -50 000 төгрөг.

Гурав. Мөнгөн дэмжлэг олгох журам

3.1. Журмын хоёрт заасан нөхцөл байдал үүсвэл тухайн шүүхийн Ахмадын зөвлөлийн тэргүүн нь үндэслэл бүхий саналаа Холбооны ажлын албанд ирүүлнэ.

3.2. Гишүүнд мөнгөн дэмжлэг үзүүлэхдээ Холбооны тэргүүн тушаал гаргана.

3.3. Ажлын алба мөнгөн дэмжлэг олгох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

Дөрөв. Хуримтлал төвлөрүүлэхээс чөлөөлөх үндэслэл

4. Доорхи үндэслэл бүхий нөхцөл байдал үүсвэл тухайн гишүүнийг хуримтлал нэгтгэн төвлөрүүлэхээс чөлөөлж болно.

4.1. Гишүүн 90, түүнээс дээш насанд хүрсэн /зөвхөн төрсөн он, сар, өдрийг үндэслэн тооцно/,

4.2. Байнгын хэвтэр, бусдын асаргаанд орсон,

Тав. Хуримтлал төвлөрүүлэхээс чөлөөлөх журам



Шүүхийн ахмадуудын холбоо

5.1. Журмын дөрөвт заасан үндэслэл бүхий тохиолдолд гишүүний бичгээр гаргасан хүсэлт, дээрхи нэхцэл байдал үүссэн тухай харьялах баг, хорооны Засаг дарга /шаардлагатай бол Өрхийн эрүүл мэндийн төв/- ийн тодорхойлолтыг хавсарган тухайн гишүүнийг хуримтлалаас чөлөөлүлэх санаалаа Холбооны Ажлын албанд ирүүлнэ.

5.2. Ажлын алба материалыг хянаж Холбооны тэргүүнд танилцуулснаар тухайн гишүүнийг төвлөрсөн хуримтлалаас чөлөөлөх, эсэхийг шийдвэрлэн энэ тухай Салбар зөвлөлд нь хариу мэдэгдэж, гишүүдийн нэгдсэн бүртгэлд тухай бүр тэмдэглэгээ хийнэ.

5.3. Гишүүнийг хуримтлалаас чөлөөлөхдөө Холбооны тэргүүн тушаал гарган шийдвэрлэнэ.

Зургаа. Татвар хуримтлалыг хөнгөрүүлэн тогтоох.

Доорхи үндэслэл тогтоогдвол гишүүний татвар хуримтлалын хэмжээг хөнгөрүүлэн тогтоож болно:

6.1. Өмнө шүүгчээр ажиллаж байсан боловч тэтгэвэрт гараадаа өөр албан тушаал эрхэлж байсан, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нь үндэслэл бүхий баримтаар тогтоогдох, тухайн гишүүн татвар хуримтлалыг хөнгөрүүлэх хүсэлт бичгээр гаргасан,

6.2. Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй нь үндэслэл бүхий баримтаар тогтоогдох, тухайн гишүүн татвар хуримтлалыг хөнгөрүүлэх хүсэлт бичгээр гаргасан,

6.3. Журамын 6.1, 6.2 хэсэгт заасан үндэслэл тогтоогдвол гишүүний бичгээр гаргасан хүсэлт, түүнийг үндэслэх баримтыг үндэслэн зөвхөн Холбооны тэргүүний шийдвэрээр гишүүний төвлөрүүлэх татвар хуримтлалын хэмжээг 50 хүртэл хөнгөрүүлэн тогтоож болно.

6.4. Гишүүний хүсэлтийг хангах үндэслэлгүй гэж үзвэл албан бичгээр хариу өгнө.

Холбооны тэргүүний шийдвэр гараагүй байхад Зөвлөлийн тэргүүн гишүүний татвар хуримтлалын хэмжээг өөрчлөн тогтоохыг хориглоно.

Долоо. Ахмадын зөвлөлд урамшил олгох үндэслэл, журам

7.1. Хуримтлалын оны үлдэгдэлгүй, эсхүл өмнөх үлдэгдлийг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор багтаан нөхөн төвлөрүүлсэн Салбарт зөвлөл тус бүрт төвлөрүүлсэн хуримтлалын мөнгөн дүнгийн 20 хувиар жил бүр урамшуулал олгоно.

7.2. Хуримтлалын дүнг жил бүр дараа оны 1 дүгээр сарын 5-ны дотор тухайн Ахмадын зөвлөлөөс ирүүлсэн, мэдээ, тайлан, санхүүгийн баримтыг харьцуулсан дүнг үндэслэн нийт гишүүд, салбар зөвлөл бүрээр нэгтгэн гаргана.

7.3. Дүнг Удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулж, тогтоол гарган шийдвэрлүүлнэ

7.4. Тогтоолын хэрэгжилтийг ажлын алба шуурхай зохион байгуулна.

Найм. Ахмадын сангаас мөнгөн тусламж үзүүлэх үндэслэл, журам



8.1. Хүнд мэс засал, хүндээр өвчилж эмчлүүлсний зардал болон гал түймэр, байгалийн гамшигт үзэгдэлд өртөж хохирол амссан зэрэг гачигдал тохиолдсонтой холбогдуулан мөнгөн тусламж үзүүлэхийг гишүүн хүссэн тохиолдолд түүний бичгээр ирүүлсэн хүсэлтийг Холбооны ажлын алба бүртгэн авна.

8.2. Ажлын алба хүсэлтийг хянаж түүнд холбогдох материал шаардлага хангасан бол хүлээн авна. Хангаагүй бол шаардлага хангуулах үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.

8.3. Ирүүлсэн хүсэлтийг нэгтгэн Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, гишүүн тус бүрт үзүүлэх тусламжийн хэмжээг тогтоон “Ахмадын сан”-гаас тусламж олгуулахаар холбогдох тогтоол, саналыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн удирдлагад хүргүүлнэ.

8.4. Холбогдох тогтоолын хэрэгжилтэнд Холбооны дэд тэргүүн хяналт тавина.